



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код:

ХӨА-ХӨА-2025/001/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум
2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317

Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99900662

Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400

Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.28 № 1/344
танай _____ -ны № _____ -т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд нягтлан бодох бүртгэлийн Sicos программыг ашиглаж эхэлсэн ба хөгжүүлэлт дуусаагүйтэй холбоотойгоор санхүүгийн тайланг бэлтгэж гарах, аудит хийхэд цаг хугацаа хязгаарлагдмал байсан болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэр талд нийгмийн даатгалын сангаас санхүүжих дүнг тусгахгүй байгаа асуудлыг дараагийн аудитаар анхаарах асуудалд тусгаж, нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 8,136.7 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан.

Бусад асуудлын хэсэг

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргатай байгуулсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 87.4 хувийн хэрэгжилттэй, "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ /ТӨГРӨГӨӨР/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,372,973,361.16	17,662,976,084.77
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,190,483,529.72	13,989,106,329.71
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	14,190,483,529.72	13,989,106,329.71
31210	Төгрөг	14,190,483,529.72	13,989,106,329.71
31213	Арилжааны банк дахь харилцах	14,190,483,529.72	13,989,106,329.71
33	АВЛАГА	3,182,489,831.44	3,673,869,755.06
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,547,957,425.17	1,418,840,881.62
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,422,580,870.62	0.00
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.00	1,968,201,411.52
33500	Бусад авлага	211,951,535.65	286,827,461.92
33510	Байгууллагаас авах авлага	211,951,535.65	85,980,590.42
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	200,846,871.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	17,372,973,361.16	17,662,976,084.77
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,118,046,377.63	2,075,923,648.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,118,046,377.63	2,075,923,648.30
41300	Өглөг	360,369,661.23	806,049,941.85
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	360,369,661.23	0.00
41360	Бусад өглөг	0.00	806,049,941.85
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	32,846,582.56
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	728,531,362.96
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	0.00	44,671,996.33
41400	Урьдчилж орсон орлого	757,676,716.40	1,269,873,706.45
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	757,676,716.40	1,269,873,706.45
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,254,926,983.53	15,587,052,436.47
51	Засгийн газрын хувь оролцоо	16,254,926,983.53	15,587,052,436.47
51200	Хуримтлагдсан үр дүн	16,254,926,983.53	15,783,796,591.97
51210	Өмнөх үеийн үр дүн	16,002,359,870.72	16,254,926,983.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	17,372,973,361.16	17,662,976,084.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	261,646,604,369.04	246,880,780,432.79
11	ТАТВАРЫН ОРЛОГО	51,939,099,655.35	59,782,713,337.08
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	51,939,099,655.35	59,782,713,337.08
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	36,205,795,629.10	50,553,514,880.16
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,759,392,307.55	5,245,950,713.32
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,270,475,715.34	2,276,052,023.72
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	719,883,242.36	1,707,195,719.88
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	8,983,552,761.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	183,418,978.37	253,570,015.70
120	Нийтлэг татварын бус орлого	183,418,978.37	253,570,015.70
120002	Хүүгийн орлого	67,027,784.54	83,722,452.02
120003	Торгуулийн орлого	0.00	83,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,363,390.81	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,363,390.81	0.00
120009	Бусад орлого	106,027,803.02	169,764,163.68

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	209,524,085,735.32	186,844,497,080.01
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	19,135,451,161.00	39,788,830,066.01
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	19,135,451,161.00	39,788,830,066.01
1330	Төсвийн захирагчдаас	190,388,634,574.32	147,055,667,014.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	190,388,634,574.32	147,055,667,014.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	261,394,037,256.23	247,351,910,824.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	261,394,037,256.23	247,351,910,824.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,076,480.00	22,735,320.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,076,480.00	22,735,320.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	9,155,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11,076,480.00	13,580,320.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	261,382,960,776.23	247,329,175,504.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	150,557,465,495.00	179,238,418,746.35
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	150,557,465,495.00	179,238,418,746.35
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	110,825,495,281.23	68,090,756,758.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	110,825,495,281.23	68,090,756,758.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	252,567,112.81	-471,130,391.56
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	252,567,112.81	-471,130,391.56

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	263,827,919,645.87	257,551,721,837.23
11	ТАТВАРЫН ОРЛОГО	51,533,288,320.44	71,059,905,194.59
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	51,533,288,320.44	71,059,905,194.59
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	35,951,375,515.44	51,185,120,642.19
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,729,928,820.07	5,176,410,314.93
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,249,623,014.65	2,313,822,315.90
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	708,502,702.01	1,699,605,887.31
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	8,893,858,268.27	10,684,946,034.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	387,209,851.11	172,924,228.64
120	Нийтлэг татварын бус орлого	387,209,851.11	172,924,228.64
120002	Хүүгийн орлого	67,027,784.54	84,885,427.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	320,182,066.57	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	320,182,066.57	0.00
120009	Бусад орлого	0.00	88,038,800.84
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	211,907,421,474.32	186,318,892,414.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	21,518,786,900.00	39,263,225,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	21,518,786,900.00	39,263,225,400.00
1330	Төсвийн захирагчдаас	190,388,634,574.32	147,055,667,014.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	190,388,634,574.32	147,055,667,014.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	261,310,778,915.31	257,753,099,037.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	261,310,778,915.31	257,753,099,037.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,076,480.00	22,735,320.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,076,480.00	22,735,320.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	9,155,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11,076,480.00	13,580,320.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	261,299,702,435.31	257,730,363,717.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	150,474,207,154.08	189,639,606,959.24
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	150,295,315,813.00	189,639,606,959.24

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	178,891,341.08	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	110,825,495,281.23	68,090,756,758.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	110,825,495,281.23	68,090,756,758.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,517,140,730.56	-201,377,200.01
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,517,140,730.56	-201,377,200.01
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,673,342,799.16	14,190,483,529.72
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,190,483,529.72	13,989,106,329.71

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,002,359,870.72	16,002,359,870.72
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,002,359,870.72	16,002,359,870.72
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	252,567,112.81	252,567,112.81
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,254,926,983.53	16,254,926,983.53
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	16,254,926,983.53	16,254,926,983.53
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-196,744,155.50	-196,744,155.50
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,058,182,828.03	16,058,182,828.03
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	-471,130,391.56	-471,130,391.56
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	15,587,052,436.47	15,587,052,436.47

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Гүйцэтгэл хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	195,096,861,700.00	189,662,342,279.24	5,434,519,420.76	97.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	195,096,861,700.00	189,662,342,279.24	5,434,519,420.76	97.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,629,400.00	22,735,320.00	894,080.00	96.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,629,400.00	22,735,320.00	894,080.00	96.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,903,300.00	9,155,000.00	748,300.00	92.4
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	13,726,100.00	13,580,320.00	145,780.00	98.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,073,232,300.00	189,639,606,959.24	5,433,625,340.76	97.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	195,073,232,300.00	189,639,606,959.24	5,433,625,340.76	97.2
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	195,073,232,300.00	189,639,606,959.24	5,433,625,340.76	97.2
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	195,096,861,700.00	110,323,130,594.59	84,773,731,105.41	56.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39,263,225,400.00	39,263,225,400.00	0.00	100.0

310001	Улсын төсвөөс санхүүжих	39,263,225,400.00	39,263,225,400.00	0.00	100.0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	155,833,636,300.00	60,374,959,160.33	84,773,731,105.41	45.6
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	155,833,636,300.00	60,374,959,160.33	95,458,677,139.67	38.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	14,190,483,529.72	14,190,483,529.72	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	13,989,106,329.71	13,989,106,329.71	-

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой дараах алдаануудыг дараагийн аудитаар анхаарах асуудлаар орууллаа. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд нийгмийн даатгалын төв сангаас авсан санхүүжилт 147,055,667.0 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэр талд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: 54.5.1.тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /**нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр**” заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Төсвийн гүйцэтгэлийн тайланг алдаатай байдлаар илэрхийлж, тайлагнаж байгаа нь Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн чиглэл, тус салбарын хүрээнд мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу хийгдэж байгаа асуудал гэж шалгагдагч байгууллага тайлбарлаж байгаа тул дээд шатны байгууллагын түвшинд шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.
2. Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглаварт хугацаанд аудит хийхээр төлөвлөсөн боловч сангийн нягтлан бодох бүртгэлд шинэ систем нэвтрүүлж, хөгжүүлэлт хийх ажил удаашралтай байснаас 2025 оны 3 дугаар сарын 05-нд санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад ирүүлсэн. Системд мэдээлэл оруулж эцэслэх ажил нь 2025 оны 3 дугаар сарын 26-нд дууссан тул аудитын дүгнэлт гаргах хугацаа тодорхой хэмжээнд хойшилсон болно. Цаашид жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж гаргах цаг хугацаатай давхцуулан санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой ажил төлөвлөхгүй байхад анхаарч ажиллах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 8,136.7 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг мөнгөн гүйлгээтэй тулган шалгахад тэтгэврийн зардлыг 8,136.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” 2.4 (б) санхүүгийн тайланд төсвийн байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, нэмэлт тайлбар, тодруулгыг үнэн зөв толилуулна” заалттай нийцэхгүй ба “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт өгөөгүй

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг мөнгөн гүйлгээний тайланд алдаатай илэрхийлсэн	1	8,136.7			1	8,136.7	1	8,136.7				
Дүн	1	8,136.7			1	8,136.7	1	8,136.7				